



ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ : ҮНДСЭН ХУУЛИУД

Үндсэн хууль гэж юу вэ?

Хэд хэдэн онуудад батлагдаж байв.

Мэддэг, онцлох ямар заалтууд байдаг вэ?



Хичээлийн зорилго

1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудад хүний эрх, эрх чөлөө, төрийн байгууллагын эрх үүргийн талаар хэрхэн туссан болохыг дүгнэх



Харьцуулан
шинжлэх

Асуудал
дэвшүүлэх

Үндэслэлтэй
тайлбарлах



ҮНДСЭН ХУУЛИУД

Харьцуулсан шинжилгээ хийж үзье.



1924 он

Хэзээ:
1924 он
11 сарын 25. 16:17

Хэмжээ:
6 бүлэг, 50 зүйл

Засаглалын хэлбэр:
Хэмжээт эрхт хаант
засаглал

Онцлог:
1924 онд анхны Үндсэн
хуулийг баталснаар дэлхий
дээрх хоёр дахь социалист улс
болсон.

**Төрийн эрх барих дээд
байгууллага:**
Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын дээд эрхийг Улсын Их
Хуралд хадгалах бөгөөд мөн
хурлын чөлөө цагт Улсын
Бага хуралд хадгалуулах ба
бас мөн хурлын чөлөө цагт
Бага хурлын тэргүүлэгчид
ба Засгийн Газрын дунд
хадгалуулбал зохино.



1940 он

Хэзээ:
1940 он
6 сарын 30

Хэмжээ:
12 бүлэг, 108 зүйл

Засаглалын хэлбэр:
Авторитари

**Төрийн эрх барих дээд
байгууллага:**
Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын төрийн эрхийг барих
дээд газар нь Улсын Их
Хурал мөн. Улсын Их хурлыг
3500 хүн тутмаас нэжгээд
депутатаар бодож, сонгуулийн
тойргуудаар Бүгд Найрамдах
Монгол Ард Улсын иргэд
сонгоно. Улсын Их Хурлыг
дөрвөн жилийн хугацаагаар
сонгоно.



1960 он

Хэзээ:
1960
7 сарын 6

Хэмжээ:
10 бүлэг, 94 зүйл

Засаглалын хэлбэр:
Авторитари

Онцлог:
1924, 1940, 1960 оны Үндсэн
хуулиудад шашин шүтэх,
эвлэлдэн нэгдэх, үг хэлэх,
хэвлэн нийтлэх зэрэг эрх,
эрх чөлөөг тунхагласан
боловч бодит байдал дээр
хэрэгжих боломжгүй бөгөөд
хориглогддог байлаа.

**Төрийн эрх барих дээд
байгууллага:**
Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын төрийн эрхийг барих
дээд байгууллага нь Ардын Их
Хурал юм.



1992 он

Хэзээ:
1992 он
1 сарын 13. 11:35

Хэмжээ:
6 бүлэг, 70 зүйл

Засаглалын хэлбэр:
Парламентын засаглалтай
Бүгд Найрамдах улс

**Төрийн эрх барих дээд
байгууллага:**
Монгол Улсын Их Хурал
бол төрийн эрх барих дээд
байгууллага мөн бөгөөд хууль
тогтоох эрх мэдлийг гагцхүү
Улсын Их Хуралд хадгална.
Улсын Их Хурал нэг
танхимтай, далан зургаан
гишүүнтэй байна. ■



ҮНДСЭН ХУУЛИУД

Анхдугаар Үндсэн хууль



Ардын
Засгийн
газрын мөрийн
хөтөлбөр

Швейцарь мэт төвийг сахисан улс байх

Дотоод гадаад худалдааг хөгжүүлэх

Олон их бага улстай гэрээ болзоо тогтоон ажиллах

Монгол үндэстнээ дуртай аваас оруулах

Гадаад улсуудад залуучуудаа сургах

Хувийн өмчийг дэмжих



ҮНДСЭН ХУУЛИУД

Анхдугаар Үндсэн хууль

Монголын
жинхэнэ ардын
эрх чөлөөг илтгэн
тунхаглах нь


Улсын тамга ба
сүлд тэмдэг, туг
далбаа гурвын
тухай

Улсын дээд
эрхийг барих
газрын тухай

Улсын орлого
зарлагын эрхийн
тухай

Нутгийн
захиргааны тухай


Сонгох, сонгогдох
эрхийн тухай






ҮНДСЭН ХУУЛИУД

Анхдугаар Үндсэн хууль




“Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн Эрхтэй Ард Улс хэмээж, улсын дээд эрхийг **жинхэнэ ардад** эзлүүлэн, улсын аливаа хэргийг **Улсын их хурал** мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино”.

Үндсэн хуулийн 1-р зүйл



Үндсэн хуульд тус улсын харьяат ард түмэнд угсаа, шашин, **эрэгтэй эмэгтэй хэмээн ялгаварлахгүй** нэгэн адил эрхийг эдлүүлэх, эвлэлдэх, эрдэм боловсролд үнэ төлбөргүй суралцах, бусдын хөдөлмөрийг мөлждөггүй, 18 насанд хүрсэн иргэн бүхэн сонгох, сонгогдох эрхтэйг тунхаглажээ.



Шашны хэргийг улс төрийн хэргээс тусгаарлаж, шашин шүтлэгийн явдлыг иргэдийн өөрсдийн дур сүсгээр болговоос зохино гэжээ.



Урьдын ван, гүн, хутагт хувилгаад, сүм хийдэд данстай лам нар, бусдын хөдөлмөрийг мөлжин амьдрагчид, мөнгө хүүлэгчид зэрэг нийгмийн зарим хэсгийнхний сонгуулийн эрхийг эдлүүлэхгүй байхаар заажээ.



ҮНДСЭН ХУУЛИУД

1940 оны Үндсэн хууль

Улсын VIII их хурал

БНМАУ-ын Үндсэн хуулийн тухай илтгэлийг Х. Чойбалсан тавьж хэлэлцүүлэв.

1940.VI.30

Үндсэн хуулийг батлав. Уг Үндсэн хууль 12 бүлэг, 95 зүйлээс бүрдсэн байна.

Үндсэн хууль

Тус орны нийгмийн байгууллын хөгжлийн онцлог, мөн чанарыг шинээр тодорхойлсон.



ҮНДСЭН ХУУЛИУД

1940 оны Үндсэн хууль



“БНМАУ болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орон юугаа хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, сэхээтэн) ардын тусгаар тогтносон улс мөн болно”.

1940 оны Үндсэн хууль 1-р зүйл



Бүх газар, түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик завод, төмөрлөг алт боловсруулах явдал, төмөр зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйтнууд улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн.

1940 оны Үндсэн хууль



ҮНДСЭН ХУУЛИУД

1940 оны сонгууль

Ард иргэдийн үндсэн эрх ба үүргүүд хэмээх бүлгийг тусгайлан гаргасан

Ажлын сахилга батыг сахих, аж ахуй, соёлыг бүхий л талаар хөгжүүлэхэд авьяас хүчээ дайчлан алба хаах, эх орноо хамгаалах үүргийг хуульчлан тогтоожээ.

МАХН бол улс, нийгмийн бүх байгууллагуудыг удирдан чиглүүлэгч үүрэгтэй гэж намын удирдах чиглүүлэх үүргийг хуульчлан тогтоожээ.



ҮНДСЭН ХУУЛИУД

1940 оны Үндсэн хууль



Монгол улсын хоёрдахь үндсэн хуулийг боловсруулах комисс ард олон түмнийхээ санал авч байна. 1940 он



Б.Н.М.А.Улсын Үндсэн хууль баталсантай холбогдуулан хөдөлмөрчдийн баяр жанжин Сүхбаатарын талбайд болов. 1940 он



Үндсэн хууль боловсруулах комиссын хурал





ҮНДСЭН ХУУЛИУД

1940 оны Үндсэн хууль



Б.Н.М.А.Улсын Үндсэн хуулийг
Улсын наймдугаар их хурлаар хэлэлцэж байгаа нь

Б.Н.М.А.Улсын Үндсэн хуулийг
эгсэсэн батаав. 1940 он





ҮНДСЭН ХУУЛИУД

1960 оны Үндсэн хууль

БНМАУ бол “ажилчид, хоршоолсон ардууд, (малчид, тариачид) хөдөлмөрч сэхээтний улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн”

БНМАУ-ын эдийн засгийн үндэс бол үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээрээ өмчлөх социалист өмч мөн.

Бүх хүчин чадал, эрдэм мэдлэгээ социализм байгуулах үйлсэд бүрнээ зориулах, Үндсэн хуулийг ёсчлон сахих хуульчилсан.

БНМАУ бол төр, нийгмийн удирдан чиглүүлэх хүч бол... Монгол Ардын Хувьсгалт нам мөн.

1960 оны Үндсэн хууль нь шинж чанарын хувьд социалист хэв маягийн Үндсэн хууль байв.



ҮНДСЭН ХУУЛИУД

1992 оны Үндсэн хууль

Үндсэн хууль

Үндсэн хуулийн төслийг 7000 гаруй байгууллага, 900,000 гаруй хүн оролцож, 200 мянга гаруй санал гарчээ.

Үндсэн хууль

УБХ 2 удаа хэлэлцэж, АИХ-д оруулжээ. 1992 оны 1 сарын 13-нд баталсан байна.

Үндсэн хууль

Монгол Улсад нэг шаттай парламент, Ерөнхийлөгчийн институт бүхий бүгд найрамдах засаглалын ардчилсан хэлбэрийг хуульчлан баталгаажуулсан юм.



ҮНДСЭН ХУУЛИУД



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдүгээр бүлэг

Нэгдүгээр зүйл.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ


1.Монгол улсын үндсэн хуулийн цэц /цаашид "цэц" гэнэ/ бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зорчсон тухай дүгнэлт гаргах,маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага,Үндсэн хуулийг чандлан сахнуулах баталгаа мөн.



Ардын их хурлын хуралдааны танхимд:
баруунаасаа: Хууль зүйн сайд
Ж.Амарсанаа,Улсын бага хурлын зөвлөх
С.Томор,Ерөнхийлөгчийн зөвлөх
Н.Лувсанжав 1992,1,13



МОНГОЛ УЛСЫН АНХНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ПУНСАЛМААГИЙН ОЧИРБАТ
ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН УГ ЭХИЙГ ГАРЫН ҮСЭГ ЗУРЖ БАТЛАМЖЛАВ.





ҮНДСЭН ХУУЛИУД



1992 ОНООС ЭХЛЭН МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАР ПАРЛАМЕНТЫН ЗАСАГТАЙ БОЛЖ, ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДАЙГ УЛСЫН ИХ ХУРАЛ, ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДАЙГ ЕРӨНХИЙЛОГЧ ЗАСГИЙН ГАЗАР ЭДЛЭХ БОЛСОН ЮМ. ПАРЛАМЕНТАД ОЛОН НАМЫН ТӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ИХ ХУРАЛЫН ГИШҮҮД СОНГОГДОН АЖИЛААХ БОЛСОН БИЛЭЭ.



1

ТӨСӨЛ
1991-5-23

МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ
/Гийцсэн хууль/

31/21 Ямар гэлцэлтэй
Холбооны хууль
Тусламж ав.
10/10/91

Монголын ард түмэн бид:

- Хүннй эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандиглан эсгэмжлж,
- ~~уламжлал~~
-эх эрнхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүн төрөлхтний соёл иргэнийгт хүндэтгэн,
- Эх орондоо
-Монгол нутагт хүнийг, ардчилсан нийгмийг төгцлөн хөгжүүлэх зорилгоор, улсын Их цаазыг даяар олонд зарлан тунхаглаж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ
БАЙДЛЫГ ИМГГЭН ТУНХАЛНАХ НЭ

Нэгдүгээр зүйл

Монгол улс бол бүрэн эрхт, тусгаар тогтносон, хууль цаазат, ардчилсан улс мөн.

Хоёрдугаар зүйл

1. Монгол улс нь төрийн байгуулалтын хувьд нэгдсэн улс байна. ~~Түүний нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжид хуваагдана.~~

Гуравдугаар зүйл

1. Монгол улсад төрийн эрхт ард түмний мэдээлд байна. Мон-



ҮНДСЭН ХУУЛИУД



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
2000 оны 10-дугаар сарын 14-ний өдөр
Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд дараах заалт нэмсүгэй:

1/ Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт:

"Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэс хойш дачин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эхлүүлж Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргаж."

2/ Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт:

"Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ."

Хоёрдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, хорин долдугаар зүйлийн 2, 6 дахь хэсэг, хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугэй:

1/ Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотор нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно."

2/ Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"Улсын Их Хурлын ээлжит чуулган хэлэс жил тутам нэг удаа тавинас доошгүй ажлын өдөр чуулна."

3/ Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хуралцан ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ."

4/ Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийгээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хэвсрэн болногүй."

5/ Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2:

"2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах."

Гуравдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

2000 оны арван хоёрдугаар сарын 14-ний өдрийн 16 цаг 15 минут буюу арван долдугаар жарны төмөр луу жилийн өвлийн тэргүүн улаагчин гахай эрх зөвшөөрөгчдийн эвслийн Зайвчлагчтай элэлжит сэдэн үзсэн мөрийн өдрийн бичиг цаг.

Улаанбаатар хот

Хуульд оруулсан өөрчлөлийн Ерөнхий хэргийн бичгийн дарга

Б.ЭНЭБИШ

"МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛ ТӨРИЙН
ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛАГА МӨН БӨГӨӨД
ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДНИЙГ ГАЦХУУ
УЛСЫН ИХ ХУРАЛД ХАДГАЛНА"

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС

- Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд Найрамдах улс мөн.
- Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.


1992 оны Үндсэн хууль
Нэгдүгээр бүлэг. Нэгдүгээр зүйл 1.2

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

Хууль тогтоох
эрх мэдэл

Гүйцэтгэх эрх мэдэл

Шүүх эрх мэдэл





ҮНДСЭН ХУУЛИУД

Хүний эрх, эрх чөлөө

1924	1940	1960	1992
<p>- 35.3 Сонгох, сонгогдох эрхгүй хүмүүс Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан, лам нар</p>	<p>- БНМАУ-ын 18 насанд хүрсэн бүх иргэн нас, хүйс, шашин шүтлэг, эрдэм чадвар, эд хөрөнгө, нүүдлийн ба суурьшмал байдлыг харгалзалгүй сонгох, сонгогдох эрхтэй гэж заажээ.</p>	<p>- Эрэгтэй, эмэгтэй, арьс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаварлахгүй тэгш эрхтэй байх,</p>	<p>- Амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах гэх мэт</p>



ҮНДСЭН ХУУЛИУД

1924	1940	1960	1992
<p>Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дээд эрхийг Улсын Их Хурал хадгалах бөгөөд мөн хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах ба бас мөн хурлын чөлөө цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба мөн хурлын чөлөө цагт Засгийн Газрын дунд хадгалуулбал зохино.</p>	<ul style="list-style-type: none">- БНМАУ-ын төрийн үндэс нь бүх шатны ардын хурал гэж хуульчилсан.- МАХН-ыг “Улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүч” хэмээн тодорхойлсон.- Социалист маягт дөхсөн, ангийн шинж чанартай хууль байв.	<ul style="list-style-type: none">- Тус улсын улс төрийн үндэс нь бүх шатны Ардын Депутатын Хурал болсон байна.- БНМАУ-ын төр, нийгмийн удирдан чиглүүлэх хүч бол... Монгол Ардын Хувьсгалт Нам мөн.- Шинж чанарын хувьд социалист хэв маягийн Үндсэн хууль байв.	<ul style="list-style-type: none">- Хууль тогтоох- Гүйцэтгэх- Шүүх



ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

1924, 1940, 1960, 1992 онуудын Үндсэн хуулиудын
талаар судлаарай



2020.05.25-с мөрдөгдөж эхэлсэн Үндсэн хуулийн
нэмэлт өөрчлөлтийг уншина уу.

Хэд хэдэн эх сурвалжийг харьцуулж, дүгнэх



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА